



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013. 6. 05 № 120 ЧАГ-САГ/2013 /СТА-ЗГСНТ

Зөрчил арилгуулах тухай

Засгийн газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- 2011 онд Мал хамгаалах сангаар дамжуулан ноосны урамшуулалд олгосон урсгал төсвийн санхүүжилтийн 9,849,932,924.00 төгрөгийг Төрийн сангийн 33060301 дугаар дансанд авлагаар бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2-д “санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх”, Төсвийн тухай хуулийн 12.1.6-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлд хяналт тавих” гэсэн заалтыг зөрчиж байна.

“Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтыг үндэслэн дараах Албан шаардлагыг өгч байна.

Дээр дурдсан 9,849,932,924.00 төгрөгийн зөрчил дутагдлыг арилгаж, биелэлтийг 2013 оны 11 дүгээр сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн сангийн газрын дарга Ч.Тавинжил, Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын дарга Т.Доржханд нарт даалгав.

АХЛАХ АУДИТОР



Г.ЮРА